

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/177/НА-СТА-ТШЗ

Баянхонгор аймаг 2022 оны 02 дугаар сар	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: TseenyamA@audit.gov.mn Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: Л.Доржханд Утас: 99093683 Цахим хаяг: dorjkhndl@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Агуулга

2.Аудитын санал дүгнэлт /эх хувь/	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт	16
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Аудитын зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.21 № 2/32

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\4-12 Цэцэрлэг 2-32-20220221.docx

• 0050?0?70

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>72,108,958.00</u>	<u>107,957,745.12</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	72,108,958.00	107,957,745.12
351	Түүхий эд материал	41,287,688.00	53,712,025.00
35110	Тусгай зориулалттай материал	39,228,888.00	48,925,650.00
35130	Эм боох материал	2,058,800.00	4,786,375.00
354	Хангамжийн материал	30,821,270.00	54,245,720.12
35410	Бичиг хэргийн материал	955,720.00	2,896,750.00
35420	Аж ахуйн материал	10,380,501.00	17,209,109.99
35450	Барилгын засварын материал	00.00	9,584,150.00
35460	Хүнсний материал	00.00	647,461.13
35470	Бусад хангамжийн материал	19,485,049.00	23,908,249.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>490,577,212.39</u>	<u>500,928,938.49</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	490,577,212.39	500,928,938.49
392	Биет хөрөнгө	399,202,212.39	409,553,938.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	401,188,618.99	405,339,618.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-34,257,865.16	-50,058,242.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,221,753.55	51,997,716.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,557,468.77	-24,925,619.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,738,969.45	43,722,177.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,766,459.35	-19,456,376.30
39217	Ном	2,634,663.68	2,934,663.68
393	Биет бус хөрөнгө	91,375,000.00	91,375,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	91,375,000.00	91,375,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>562,686,170.39</u>	<u>608,886,683.61</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>562,686,170.39</u>	<u>608,886,683.61</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	562,686,170.39	608,886,683.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	91,375,000.00	91,375,000.00
51101	Өмч: - төрийн	91,375,000.00	91,375,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	461,511,697.27	507,712,210.49
51210	Өмнөх үеийн үр дүн	461,511,697.27	461,511,697.27
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	46,200,513.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,799,473.12	9,799,473.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>562,686,170.39</u>	<u>608,886,683.61</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	400,181,660.00	462,668,228.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,388,500.00	11,729,912.00

Аудитын код **БНА-2022/177/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	5,388,500.00	11,729,912.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/	5,388,500.00	5,925,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/		5,804,912.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	394,793,160.00	450,938,316.48
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	347,454,400.00	383,749,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,097,360.00	28,315,594.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,097,360.00	24,559,594.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,756,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,241,400.00	38,873,022.48
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,241,400.00	38,873,022.48
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	389,266,482.96	415,861,738.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	389,266,482.96	415,861,738.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	373,846,129.13	385,007,621.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,927,736.00	264,652,184.00
210101	Үндсэн цалин	224,448,114.00	212,255,717.00
210102	Нэмэгдэл	00.00	28,797,867.00
210104	Урамшуулал	22,479,622.00	23,598,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,239,122.00	35,736,587.31
210201	Тэтгэврийн даатгал	21,345,858.00	25,144,284.02
210202	Тэтгэмжийн даатгал	2,511,277.00	2,675,574.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,002,302.00	2,114,374.00
210204	Ажилгүйдлийн даатгал	489,061.00	532,335.40
210205	Эрүүл мэндийн даатгал	4,890,624.00	5,270,019.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,773,881.67	33,373,022.48
210301	Гэрэл, цахилгаан	2,504,375.67	2,477,076.48
210302	Түлш, халаалт	28,295,250.00	28,295,250.00
210303	Цэвэр, бохир ус	2,974,256.00	2,600,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,231,987.50	5,841,460.13
210401	Бичиг хэрэг	122,180.00	583,270.00
210402	Тээвэр, шатахуун	366,500.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	757,907.50	810,956.13
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	545,800.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	263,600.00	1,863,235.00
210408	Бараа материал акталсны зардал	176,000.00	1,183,999.00
2105	Нормативт зардал	31,224,270.45	12,045,221.88
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	357,300.00	1,008,175.00
210502	Хоол, хүнс	29,533,670.45	10,390,046.87
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,333,300.00	647,000.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,442,600.00	5,074,850.00
210604	Урсгал засвар	3,442,600.00	5,074,850.00
2107	Томилолт, зочны зардал	24,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	24,000.00	00.00

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	814,000.00	1,187,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	514,000.00	606,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	350,000.00
		00.00	231,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,168,531.51	27,096,696.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	537,700.00	1,489,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,787,000.00	2,316,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,843,831.51	23,291,496.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,420,353.83	30,854,116.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,047,360.00	25,359,594.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	16,055,584.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,097,360.00	8,504,010.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	950,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,967,518.33	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,967,518.33	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,405,475.50	5,494,522.56
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,405,475.50	5,494,522.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10,915,177.04	46,806,489.93
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	48,875.00	605,976.71
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	48,875.00	605,976.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-48,875.00	-605,976.71
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,866,302.04	46,200,513.22


2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	394,793,160.00	450,938,316.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	394,793,160.00	450,938,316.48
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	347,454,400.00	383,749,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,097,360.00	28,315,594.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,097,360.00	24,559,594.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,756,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,241,400.00	38,873,022.48
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,241,400.00	38,873,022.48
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	386,476,860.00	422,614,117.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,476,860.00	422,614,117.48

Аудитын код **БНА-2022/177/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,056,506.17	391,760,000.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,927,736.00	264,652,184.00
210101	Үндсэн цалин	198,280,611.00	212,255,717.00
210102	Нэмэгдэл	28,821,225.00	28,797,867.00
210104	Урамшуулал	19,825,900.00	23,598,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,239,122.00	35,736,587.31
210201	Тэтгэврийн даатгал	21,345,859.00	25,144,284.02
210202	Тэтгэмжийн даатгал	2,511,278.00	2,675,574.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,002,302.00	2,114,374.00
210204	Ажилгүйдлийн даатгал	489,063.00	532,335.40
210205	Эрүүл мэндийн даатгал	4,890,620.00	5,270,019.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,773,881.67	33,373,022.48
210301	Гэрэл, цахилгаан	2,504,375.67	2,477,076.48
210302	Түлш, халаалт	28,295,250.00	28,295,250.00
210303	Цэвэр, бохир ус	2,974,256.00	2,600,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,567,607.50	13,025,199.13
210401	Бичиг хэрэг	267,400.00	2,213,900.00
210402	Тээвэр, шатахуун	366,500.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	847,907.50	810,956.13
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	545,800.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,540,000.00	8,600,343.00
2105	Нормативт зардал	32,275,710.00	16,038,708.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,516,100.00	849,000.00
210502	Хоол, хүнс	22,737,410.00	11,037,508.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,022,200.00	4,152,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,717,100.00	18,786,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	640,700.00
210602	Тавилга	00.00	44,000.00
210604	Урсгал засвар	3,717,100.00	18,102,000.00
2107	Томилолт, зочны зардал	24,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	24,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	1,236,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	514,000.00	646,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,717,349.00	8,911,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,694,549.00	3,552,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,022,800.00	5,359,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,420,353.83	30,854,116.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,047,360.00	25,359,594.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	16,055,584.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,097,360.00	8,504,010.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	950,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,967,518.33	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,967,518.33	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,405,475.50	5,494,522.56
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,405,475.50	5,494,522.56



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,316,300.00	28,324,199.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,316,300.00	28,324,199.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,316,300.00	28,324,199.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,316,300.00	28,324,199.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,316,300.00	28,324,199.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,316,300.00	-28,324,199.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	91,375,000.00	9,799,473.12	461,511,697.27	00.00	562,686,170.39
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,375,000.00	9,799,473.12	461,511,697.27	00.00	562,686,170.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,375,000.00	9,799,473.12	461,511,697.27	00.00	562,686,170.39
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	46,200,513.22	00.00	46,200,513.22
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,375,000.00	9,799,473.12	507,712,210.49	00.00	608,886,683.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	425,919,600.00	417,128,199.92	8,791,400.08	97.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,919,600.00	417,128,199.92	8,791,400.08	97.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,843,100.00	416,328,199.92	8,514,900.08	98.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,784,200.00	264,652,184.00	3,132,016.00	98.83
210101	Үндсэн цалин	214,754,100.00	212,255,717.00	2,498,383.00	98.84
210102	Нэмэгдэл	29,431,500.00	28,797,867.00	633,633.00	97.85

Аудитын код **БНА-2022/177/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	23,598,600.00	23,598,600.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,555,900.00	35,736,587.31	819,312.69	97.76
210201	Тэтгэврийн даатгал	25,694,800.00	25,144,284.02	550,515.98	97.86
210202	Тэтгэмжийн даатгал	2,715,300.00	2,675,574.78	39,725.22	98.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,172,200.00	2,114,374.00	57,826.00	97.34
210204	Ажилгүйдлийн даатгал	543,100.00	532,335.40	10,764.60	98.02
210205	Эрүүл мэндийн даатгал	5,430,500.00	5,270,019.11	160,480.89	97.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,669,900.00	33,373,022.48	3,296,877.52	91.01
210301	Гэрэл, цахилгаан	4,113,600.00	2,477,076.48	1,636,523.52	60.22
210302	Түлш, халаалт	28,310,300.00	28,295,250.00	15,050.00	99.95
210303	Цэвэр, бохир ус	4,246,000.00	2,600,696.00	1,645,304.00	61.25
2104	Хангамж, бараа материалын зардал	13,325,200.00	13,325,199.13	0.87	100.00
210401	Бичиг хэрэг	2,213,900.00	2,213,900.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	1,000,000.00	300,000.00	76.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	959,600.00	810,956.13	148,643.87	84.51
210404	Ном, хэвлэл	363,300.00	300,000.00	63,300.00	82.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	400,000.00	-300,000.00	400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,388,400.00	8,600,343.00	-211,943.00	102.53
2105	Нормативт зардал	17,287,200.00	16,038,708.00	1,248,492.00	92.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	849,000.00	849,000.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	12,286,000.00	11,037,508.00	1,248,492.00	89.84
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,152,200.00	4,152,200.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,307,000.00	42,306,899.00	101.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,810,000.00	13,810,000.00	0.00	100.00
210602	Тавилга	10,000,000.00	9,999,899.00	101.00	100.00
210604	Урсгал засвар	18,497,000.00	18,497,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	18,100.00	00.00	18,100.00	0.00
210702	Дотоод албан томилолт	18,100.00	00.00	18,100.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,236,600.00	1,236,600.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	646,600.00	646,600.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9659000.00	9659000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4300000.00	4300000.00	0.00	100.00



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,359,000.00	5,359,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1076500.00	800000.00	276,500.00	74.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,076,500.00	800,000.00	276,500.00	74.31
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,076,500.00	800,000.00	276,500.00	74.31
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	425,919,600.00	417,128,199.92	8,791,400.08	97.94
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	383,749,700.00	378,255,177.44	5,494,522.56	98.57
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	383,749,700.00	378,255,177.44	5,494,522.56	98.57
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,169,900.00	38,873,022.48	3,296,877.52	92.18
132001	Орон нутгийн төсвөөс	42,169,900.00	38,873,022.48	3,296,877.52	92.18
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0.00	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	168.00	150.00	18.00	89.29
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	168.00	150.00	18.00	89.29
630001	Төрийн өмчит ЕБС	168.00	150.00	18.00	89.29
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00	0.00	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,097,360.00	28,315,594.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,097,360.00	28,315,594.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,756,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,756,000.00



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,756,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,097,360.00	24,559,594.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,097,360.00	24,559,594.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		16,055,584.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,097,360.00	8,504,010.00
1	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		28,315,594.00
1311	Нэмэлтийн санхүүжилтийн орлого		28,315,594.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,097,360.00	24,559,594.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,756,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 92 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тус байгууллагын дарга Ч.Олддоггүй нэгдүгээр гарын үсэг, нягтлан бодогч С.Байгалмаа хоёрдугаар гарын үсгийг зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэг нь хүүхэд багачуудад сургуулийн өмнөх боловсрол олгох, аймгийн БСУГ-аас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс хичээл, сургалтыг үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.

Тус байгууллага нь тайлант онд 160 хүүхэд хамрагдахаас 150 хүүхэд хамрагдаж 90 хүүхэд цахимаар, 60 хүүхэд танхимаар орж 26 орон тоотой ажилласан бөгөөд тайлант онд 425,919.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын даргын 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/07 дугаартай тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн баталсан нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 389,266.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,892.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,919.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3,118.9 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,200.5 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,109.0	107,957.7	35,848.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	72,109.0	107,957.7	35,848.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	490,577.2	500,928.9	10,351.7
Үндсэн хөрөнгө	568,929.0	596,139.2	27,210.2
Хуримтлагдсан элэгдэл	(78,351.8)	(95,210.2)	(16,858.4)
Нийт хөрөнгө	562,686.2	608,886.7	46,200.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	562,686.2	608,886.7	46,200.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	562,686.2	608,886.7	46,200.5

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 107,957.7 мянган төгрөг болж 35,848.8 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,941.0 мянга, аж ахуйн материал 6,828.6 мянга, бусад хангамжийн материал 4,423.2 мянга, хүнсний материал 647.5 мянга, барилгын засварын материал 9,584.1 мянга, эм боох материал 2,727.6 мянга, тусгай зориулалтын материал 9,696.7 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Энэ нь БШУЯ-наас олгосон 4,861.2 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, Баянхонгор аймгийн ЗДТГ-аас олгосон ариутгалын бодис 90,0 мянга, сумын ЗДТГ-аас олгосон халууны шил, нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгсэл 510.0 мянга, НҮБ-аас олгосон ариутгалын бодис 110.0 мянга, БСУГ-аас олгосон тусгаарлах гэрийн багц 123,7 мянга, нийт 5,804.9 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүй шилжүүлэн авсан ба төсвийн хөрөнгөөр 55,084.7 мянган төгрөгийн бараа материал авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 596,139.2 мянган төгрөг болж 27,210.2 мянган төгрөгөөр өссөн БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 5,925.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 24,568.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэнтэй холбоотой бөгөөд тайлант онд аймгийн ИТХ-ын



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тэргүүлэгчдийн 2021 оны 137, 156 дугаар тогтоолуудаар 7,039.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 608,886.7 мянган төгрөг болж 46,200.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 46,200.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 542,189.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 542,189.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 104,595.5 мянган төгрөгөөр бууруулж 437,593.6 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант онд төсөвт 4 удаа өөрчлөлт хийж 2021 оны 12 дугаар сард 425,919.6 мянган төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 383,749.7 мянга, орон нутгийн төсвөөс 38,873.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 383,749.7 мянга, орон нутгийн төсвөөс 42,169.9 мянга, нийт 425,919.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 417,128.2 мянган төгрөгийг зарцуулж 8,791.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 417,128.2 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 3,132.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 819.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,296.9 мянга, нормативд зардал 1,248.5 мянга, томилолтын зардал 18.1 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 276.6 мянга нийт 8,791.4 мянган төгрөгийн зардлууд хэмнэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсөвт зохицуулалт хийгдээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 16,055.6 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 8,504.0 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг, 3,756.0 мянган төгрөгийн



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж нийт 28,315.6 мянган төгрөгийн зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилго 7 зорилтой 60 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 90.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймаг, сумын онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 415,861.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 26,595.2 мянган төгрөгөөр буюу 14.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.



Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тус байгууллага нь 2021 онд нийт 454,694.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 454,694.3 мянган төгрөгийн 149 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	96	0	
	Нийт	27	151	149	0	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн системээс

3.9.2 ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ "ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 43 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

Тайлант онд 425,919.6 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 417,128.2 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал болох 100,171.2 мянган төгрөгөөс 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй оны эцэст 8,791.4 мянган төгрөг буюу төсвийн 4.8 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 36,669.9 мянган төгрөгөөр, тодотголоор 3,296.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, оны эцэст 33,373.0 мянган төгрөгийг зарцуулж бөгөөд нийт 7,334.0 мянган төгрөг хэмнэхээс 4,037.1 мянган төгрөгийг хэмнээгүй байна.

3.9.3 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил давтан гаргахгүй байх 4,037.1 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Аудитын зөвлөмж

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 425,919.6 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 417,128.2 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 20,465.4 мянган төгрөг

Аудитын код **БНА-2022/177/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор сумын 12 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

буюу төсвийн 4.8 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж:

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян. төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ										
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Шилэн данс										
2	ЗГ-ын 43 дугаар тогтоол	1	4,037.1							1	4,037.1
	Дүн	1	4,037.1							1	4,037.1
	НИЙТ ДҮН	1	4,037.1							1	4,037.1

oOo